

ХОЁР НАСТАЙ РО


Дээшилж яваа Монголын
 Дэвшинж яваа У-гийн
 Дэлгэрч яваа Сү-гийн
 Өсөж яваа Ро-гийн
 Нүд нь дүгрэг бөгөөд харавтар
 Тунгалаг толийн гэрэлтэй
 Шүд нь хурц бөгөөд жижиг
 Цагаан лавайн өнгөтэй
 Үс нь нарийн бөгөөд хархан
 Зөөлөн мяндсын ширхэгтэй
 Зүс нь бор бөгөөд хөрслөг
 Сайхан Монголын шинжтэй
 Арнун тунгалаг ухаантай
 Аз завшаан ихтэй
 Аллв хүсэл нь бүрдсэн
 Амраг хөөрхөн дүү минь
 Ангаахайн чинээ амандаа
 Алим үмхээд бувалзана.
 Аягын чинээ гэдсээ
 Амгат жимсээр дүүргэнэ.
 Төлинд байгаа дүрстэйгээ
 Тоглон ннээн наадна.
 Тохойн чинээ биеэрээ
 Бүжиг хийх гээд дэвхцэнэ.
 Аятай харагдсан бүгдийгээ
 Ай е е гэж дуудна.
 Аав ээжээ харахдаа
 Аав аа, маам аа гэж байна.

Балга хүрэхгүй шөлийг
 Барж ядан ууна.
 Үмх хүрэхгүй махыг
 Үлтэлж ядан иднэ.
 Үдээс үдэш болтол
 Үүргэлж бүр ядарчихна
 Үргэлж юм оролцоор
 Нойр нь бүр хүрчихнэ.
 Тэнд энд гишгэсээр
 Тэнтэр тунтар явна.
 Тэвдэж яарч явсаар
 Тээглэж бүдэрч ойчно.
 Бөгтөгнөж байгаад мөлхөнө.
 Бондгонож байгаад босно.
 Муу муу гээд заана.
 Хош хош гээд хараана.
 Боргоцой гараа сарвайгаад
 Боов боов гэж бархирна.
 Өгөхгүй бол уйлж гарна.
 Уйлаад унжаад ирэхлээр
 Нүүр нь улайн үрчийгээд
 Нүд нь онийн гурвалжлаад
 Нулимс нь ундран дуслаад
 Нус нь бөнжигнөн гоожоод
 Бий чадлаа шавхаад
 Биня биня гэж бархираад
 Аав ээжээ маажлаад
 Аргадаж авахыг горьдоно.
 Эрээн мярааныг харуулбал
 Ингэж уйлахаа больчихно.
 Ээж нь аваад аргадвал
 Мэмээ хөхөөд тайвширна.
 Тохойн чинээ биетэй
 Ханцуйн чинээ дээлтэй
 Бээлийн чинээ малгайтай
 Балчир нялх дүүгийн минь
 Аавдаа алт болсон
 Ээждээ сувл болсон
 Энхрий булбарай бие нь
 Эсэн мэндээр хүмүүжиг.
 Бага жаахан бие нь
 Батжин сайнаар торниг

Бадамлянхуа цэцэг мэт
 Бадран сайнаар дэлгэрэг.
 Ай хөөрхий Ро минь
 Эрэгтэй хоёрын дээр
 Эмэгтэй гурвын хамт
 Тааруухан таван дүүтэй болоорой.
 Хуучин цагийн сүүлд
 Хувьсгалт цагийн эхэнд
 Харахуй үеийн өнгөрөхөд
 Хэгээн замын нэгдэхэд
 Тохилдож төрсөн цол байна
 Олын үзэх гайхамшиг байна
 Эрдмийг сурах завшаан байна.
 Энхжин жаргах заяа байна.
 Арвидас шинийн сар шиг
 Дэлгэрэх хаврын цэцэг шиг
 Өдөр бүр өсөж байгаа
 Цаг бүр чадалжиж яваа
 Эрхэм янаг дүүдээ
 Захиx захиа, хэлэх үг
 Заах сургаал, бэлэглэх ерөөл минь
 Арав шахам наснаасаа
 А б холбосоор
 Ахих шатаа дамжаарай
 Арав тавыг нийлүүлсээр
 Дөхөх замаа олоорой.
 Бэх цаас учруулсаар
 Бичгийн эрдмийг сураарай
 Эрдэм ажлыг хосолсоор
 Эрхэм гавьяаг байгуулаарай.
 Хоёр хүрээгүй нялхдаа
 Туурайт морины дэвшгүй
 Тураг шувууны дэвшгүй
 Түмний газар хүрчиж дээ.
 Гар нь ганзаганд хүрвэл
 Гадаад далайг туулах байх.
 Хөл нь дөрөнд хүрнэл
 Хөрст дэлхийг тойрох байх.
 Ээ хөөрөн Ро минь
 Аэропланаар энд тэнд нисэж
 Галт тэргээр газар бүр зугаацаж
 Газар усны гайхамшигийг үзээрэй.

Түүнээс Монголдоо буцаж
 Төв журмаар явж
 Түвшин голомтыг байгуулж
 Түгээмэл ихээр жаргаж
 Таван ханатай гэр барьж
 Тал дүүрэн мал билчээж
 Зуул адуу ууландаа хурааж
 Мянган хонь гаднаа хотлуулаж
 Тогоо дүүрэн сүү хөөрүүлж
 Торх дүүрэн өрөм хурааж
 Суулга бүгддээ тараг бүрж
 Сав бүгддээ аари шүүж
 Шинэ ааруул хүүдийгээр гаргаж
 Шилдэг айраг хөлөгөөр сөгнөж
 Шимийн архи агаар бялхуулж
 Шингэн зөөхийн хувингаар уудалж
 Аав ээждээ өргөн дэвшүүлж
 Ах дүүдээ өгөн хүндэлж
 Халуун зуураа найрлан цэнгэж
 Харь олныг зочлон хуримлаж
 Эцэг өвгөдийн сайшаалыг сонс
 Эмгэд хөгшдийн ерөөлийг дуул
 Ард олондоо их тус бол
 Амар жаргалыг ихээр эдэл!

1935



У. Далдан Сүрэн